

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/222/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он	Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Монголиан бизнес рейтинг аудит ХХК Утас: 70005329 Цахим хаяг:mbr.audit.llc@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажилагаа.....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
8.2 Төлбөрийн акт.....	Error! Bookmark not defined.
8.3 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
8.4 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж Ахуй Нэгжийн Орлогын Албан Татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1.Аудитын санал дүгнэлт

“АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ю.ГАНЗОРИГ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Архангай АЗЗА ТӨХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Архангай АЗЗА ТӨХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Архангай АЗЗА ТӨХК нь 2009 онд олгогдсон Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлийн 198.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба 2021 оны 12-р сард Зам тээврийн хөгжлийн яам, үндэсний аудитын газрын хамтарсан хурлаар энэ асуудал яригдаж энэ талаар ЗТХЯ нь үндэсний аудитын газарт бүрэн ойлголт өгсөн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 1,314.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,288.5 сая төгрөгөөр, ашгийг 23.6 сая төгрөг байхаар тодотгож баталсан байна.

Бусад асуудал

Архангай АЗЗА ТӨХК тайлант онд 13 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийг 97.8 хувьтай гэж тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Архангай АЗЗА нь замын сангийн хөрөнгөөр улсын чанартай замын засвар арчлалтын ажлыг хариуцан гүйцэтгэж, 2021 онд 1,285.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,263.9 сая төгрөгийн зардал гарган, 19.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	331,834,998.72	273,581,656.94
1.1.2	Дансны авлага	14,140,725.33	60,605,415.32
1.1.6	Бараа материал	92,327,347.99	160,266,563.70
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	438,303,072.04	494,453,635.96
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	922,478,821.93	889,365,833.53
1.2.2	Биет бус хөрөнгө	26,193,600.00	27,293,600.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	948,672,421.93	916,659,433.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,386,975,493.97	1,411,113,069.49
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	529,330.46	866,337.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	529,330.46	866,337.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	198,657,551.00	198,657,551.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	198,657,551.00	198,657,551.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	199,186,881.46	199,523,888.00
2.3.1	Өмч: - төрийн	946,852,312.80	951,290,586.80
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	105,238,307.65	105,238,307.65
2.3.9	Хуримтлагдсан ашиг	135,697,992.06	155,060,287.04
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,187,788,612.51	1,211,589,181.49
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,386,975,493.97	1,411,113,069.49

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,370,752,073.90	1,285,442,670.91
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	938,208,177.23	1,048,366,598.24
3	Нийт ашиг (алдагдал)	432,543,896.67	237,076,072.67
10	Ерөнхий ба удирдлагын зардал	167,363,747.73	194,388,329.81
12	Бусад зардал	72,024,534.87	21,174,081.80
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	193,155,614.07	21,513,661.06
19	Орлогын татварын зардал	1,688,732.56	2,151,366.11
20	Татварын дараах ашиг (алдагдал)	191,466,881.51	19,362,294.95
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	191,466,881.51	19,362,294.95
24	Орлогын нийт дүн	191,466,881.51	19,362,294.95
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2020 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	946,852,312.80	105,238,307.65	(55,768,889.42)	996,321,731.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	946,852,312.80	105,238,307.65	(55,768,889.42)	996,321,731.03
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	191,466,881.51	191,466,881.51
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	946,852,312.80	105,238,307.65	135,697,992.09	1,187,788,612.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	946,852,312.80	105,238,307.65	135,697,992.09	1,187,788,612.54
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	19,362,294.95	19,362,294.95
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	951,290,586.8	105,238,307.65	155,060,287.04	1,211,589,181.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,554,159,530.47	1,326,526,861.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	165,888,294.99	59,273,309.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Бусад мөнгөн орлого	1,388,271,235.48	1,267,253,552.00
1.2	Мөнгөн зарлага (-)	1,246,391,065.68	1,365,633,512.78
	Ажиллагчдад төлсөн	292,929,696.00	325,557,745.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	101,363,121.02	114,565,137.52
	Бараа материал худалдан авахад төлсөн	272,256,713.78	481,066,841.36
	Ашиглалтын зардалд төлсөн	-	352,000.00
	Татварын байгууллагад төлсөн	154,104,020.65	112,323,019.90
	Бусад мөнгөн зарлага	425,737,514.23	331,768,769.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	307,768,464.79	(39,106,651.78)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	58,300,000.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	58,300,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(58,300,000.00)	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	19,146,690.00
	Төлсөн ногдол ашиг	-	19,146,690.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(19,146,690.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	249,468,464.79	(58,253,341.78)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	82,366,533.93	331,834,998.72
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	331,834,998.72	273,581,656.94

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зорилтоос	
				төлөвлөгөө	Гүйцэтгэл		
						тоо	хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	Сая.төг	1,370.8	1,314.8	1,285.4	(29.4)	-2%
Үүнээс	Улсын чанартай авто зам засвар арчлалтын ажил	Сая.төг	1,190.7	1,137.6	1,139.7	2.1	0%
	Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил	Сая.төг	42.1	86.4	88.6	2.2	3%
	Бусад орлого	Сая.төг	138.0	90.9	57.1	(-33.8)	-37%
2	Нийт орлого	Сая.төг	1,370.8	1,314.8	1,285.4	(-29.4)	-2%
3	Нийт зардал	Сая.төг	1,177.6	1,288.5	1,263.9	(-24.6)	-2%
	Үүнээс: Удирдлагын зардал	Сая.төг	167.4	194.6	194.4	(-0.2)	0%
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	Сая.төг	193.2	26.3	21.5	(-4.8)	-18%
5	Цэвэр ашиг /алдагдал/	Сая.төг	191.5	23.7	19.4	(-4.3)	-18%
6	Төсвийн төлбөрт нийт дүн	Сая.төг	209.9	222.0	237.5	15.5	7%
7	Төрийн өмчийн ногдол ашиг	Сая.төг	19.1	2.4	12.1	9.7	404%
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	36	39	36	(-3.0)	-8%
9	Нийт цалингийн сан	Сая.төг	371.7	399.4	407.4	(8.0)	2%
10	Нэг ажилтны дундаж цалин	Мян.төг	860.5	853.6	943.0	89.4	10%
11	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	Төг	0.86	0.98	0.98	-	0%
12	Хөрөнгө оруулалт	Сая.төг	58.3	25.1	25.1	-	0%
13	Нийт авлага	Сая.төг	14.1	11.7	60.6	48.9	418%
14	Нийт өглөг	Сая.төг	199.2	202.0	199.5	(-2.5)	-1%
Үүнээс	Богино хугацаат өглөг	Сая.төг	0.5	3.3	0.9	(-2.4)	-73%
	Урт хугацаат өр төлбөр	Сая.төг	198.7	198.7	198.7	-	0%

Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад НӨАТ-ын тайлангийн зөрүү, төсвийн зарцуулалт, худалдан авалт, өртөг зардал болон бусад хууль тогтоомжтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 25-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд “Монголиан бизнес рейтинг аудит ХХК-ийн аудитор А.Жамъян, туслах аудитор Г.Буянбадрах нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Н.Алтанзул, ерөнхий захирал Д.Түмэнжаргал нар хэрэгжүүлсэн.

Архангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Архангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/166 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа боловч шинэчилсэн санхүүгийн программ хангамжийн өөрчлөлтийг тусгаагүй байна.

Дотоод хяналтын хэлтэс нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд оновчтой арга хандлагаар санхүүгийн хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлж хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах, үр өгөөж, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой дүгнэлт гарган байнгын сайжруулалт хийх замаар эрсдэлийг бууруулах, засаглал ба дотоод хяналтыг үр нөлөөтэй болгоход чиглэн хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Цар тахал өвчний улмаас төлөвлөгөөт хяналт шалгалтуудыг товлосон хугацаанд хийж чадахгүй ба өмнөх оны худалдан авах ажиллагааны баримт, удирдах дээд байгууллагаас өгөгдсөн 5 үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Мөн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт тайланг хугацаатай авч, холбогдох зөвлөмж, зөвлөгөөг тухай бүр өгч ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Архангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,370.7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 27.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Архангай АЗЗА ТӨХК нь “Чадварлаг, бүтээлч хамт олныг бүрдүүлж, стандарт шаардлагад нийцсэн бүтээн байгуулалт хийж, аймаг орон нутгийнхаа хөгжилд бодитой хувь нэмэр бий болгоход оршино” гэж эрхэм зорилгоо тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 100 хувь эзэмшиж байна.

Архангай АЗЗА ТӨХК-ийн үндсэн зорилт нь төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан “Зам засвар, арчлалтын гэрээ”-ний дагуу Архангай аймгийн хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тус компани Авто замын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дэд бүтцийн хөгжилд хувь нэмэр оруулах , хариуцсан замыг чанартай засварлаж тээврийн хэрэгслийг аюулгүй саадгүй зорчуулах,
- Зам засвар арчлалт , модон болон төмөр бетон гүүр барих , засварлах,
- Шинжлэх ухааны тодорхой салбарын шинжилгээ судалгааны орчин үеийн арга барилыг эзэмшихэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах,
- Шинэ технологи , норм норматив, дүрмийг хэрэгжүүлж ажиллах,
- Иргэд , аж ахуйн нэгжид шударга үйлчилгээ үзүүлэх,

“Архангай –АЗЗА” ТӨХК-нь Монгол улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гэрээнд ордог” мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д “Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулдаг” заалтад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлж хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага болох Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь компанийн гүйцэтгэх захирлыг томилж гэрээ байгуулдаг. Гүйцэтгэх захирал компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.4.1 –д “ хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх”, 84.4.2-д “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх” , 84.4.3 –д “ Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах” гэж заасны дагуу компанийн үндсэн чиг үүрэг үйл ажиллагааг өдөр тутам удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцан ажилладаг.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасны хүрээнд

- Зам тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлтэй контрактын гэрээ байгуулан , дүгнүүлж ажилладаг.
- Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах хүрээнд өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт доор ашиглагдахгүй болсон эд материалыг акталж , жилийн эцсээр гүйцэтгэх захирлын тушаалаар тооллогын комисс томилон тооллогыг хийж гүйцэтгэдэг.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Архангай АЗЗА ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	331,835.0	273,581.7	(58,253.3)
Авлага	14,140.7	60,605.4	46,464.7
Бараа материал	92,327.3	160,266.6	67,939.2
Үндсэн хөрөнгө	922,478.8	889,365.8	(33,113.0)
Биет бус хөрөнгө	26,193.6	27,293.6	1,100.0
Нийт хөрөнгийн дүн	1,386,975.5	1,411,113.1	24,137.6
Өр төлбөрийн дүн	199,186.9	199,523.9	337.0
Богино хугацаат өглөг	529.3	866.3	337.0
Урт хугацаат өглөг	198,657.6	198,657.6	-
Эздийн өмч	1,187,788.6	1,211,589.2	23,800.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,386,975.5	1,411,113.1	24,137.6

Касс дахь бэлэн мөнгө 1.1 сая төгрөг, арилжааны банкны харилцах дансанд 272.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй, хугацаатай хадгаламж, тусгай зориулалттай мөнгө, зам яваа мөнгөн хөрөнгө байхгүй, өмнөх оноос мөнгөн хөрөнгө 58.3 сая төгрөгөөр буусан ба дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршуулсан мөнгөн хөрөнгө байхгүй.

Нийт авлага оны эхнээс 46.5 сая төгрөгөөр өсөхөд аж ААНОАТ-ын 60.6 сая төгрөгийн авлага голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 60.6 сая төгрөгийн, 1-3 сараар хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлгүй, данснаас хассан найдваргүй авлага байхгүй.

Тайлант онд ажлын төлбөрт шилжүүлсэн урьдчилгаа төлбөргүй урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 160.2 сая төгрөг болж, 67.9 сая төгрөгөөр өссөн нь Ковид 19 цар тахлын улмаас хил гааль хагдан бараа материалын олдоц хомсдохоос урьдчилан сэргийлж шаардлагатай бараа материалыг нөөцөлсөн ба үнэ төлбөргүй хүлээн авсан болон ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө оны эхний үлдэгдэл 948.7 сая төгрөг, тайлант онд шинээр худалдан авсан хөрөнгө 26.1 сая, ТӨБЗГ-ын тогтоолоор 43.5 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, ТӨБЗГ-ын тогтоолоор акталж 2.5 сая төгрөгийн хөрөнгө данснаас хасаж 916.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 32.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны 101.7 сая төгрөгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

ТӨБЗГ –ын 2020.12.08-ны № 618 тоот тогтоол буюу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 28.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан. ТӨБЗГ-ын 2021 оны 06 дугаар сарын 24-ний 286 тоот тогтоолоор Лексус 570 авто машин, ТӨБЗГ-ын 2019.11.19-ний 469 тоот тогтоолоор зөөврийн асфальт завод тус тус балансаас балансад шилжүүлж авсан. Мөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу шаардлагатай машин механизмуудад их засвар / капиталжсан/ хийсэн.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 04.13-ны А-1/661 дугаар тогтоолоор нийт 0.3 сая төгрөгийн өртөгтэй инженерүүдийн ширээ, ТӨБЗГ-ын 2020.04.21-ны 147 дугаар тогтоолоор 1.3 сая төгрөгийн үлдэх өртөгтэй навара автомашин, 0.8 сая төгрөгийн үлдэх өртөгтэй Юмз-6 тракторыг тус тус акталж балансаас хассан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 0.8 сая төгрөг болж, 0.3 сая төгрөгөөр өссөн байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 198.7 сая төгрөг ба өмнөх оноос өөрчлөлт ороогүй байна. Үүнд:

- Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлээр Төрийн өмчит бүх АЗЗА компаниудад машин механизм тоног төхөөрөмж хувиарлан өгсөн 198.6 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан.

Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй зээл байхгүй Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлийн 198.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба 2021 оны 12-р сард Зам тээврийн хөгжлийн яам, үндэсний аудитын газрын хамтарсан хурлаар энэ асуудал яригдаж энэ талаар ЗТХЯ нь үндэсний аудитын газарт бүрэн ойлголт өгсөн байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Өмнөх онтой харьцуулахад нийт зардал 21.0 сая төгрөгөөр буурсан нь бусад зардал 50.8 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт ашиглалт, засвар, үйлчилгээний зардлуудыг хамруулсан, үүнээс өртөгт хуваарилагдахгүй зардлууд байхгүй.

Эзэмшигчийн өмчийн дүн 23.8 сая төгрөгөөр өсөж, 1,211.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Архангай-АЗЗА” ТӨХК –ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 618 дугаар тогтоолоор “Архангай-АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,314.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,288.5 сая төгрөгөөр, 23.6 сая төгрөгийн ашигтай /алдагдал/ ажиллагааар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 25.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,285.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,263.9 сая төгрөгийн зардал гаргаж 19.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,314.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 29.4 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан. Нийт зардлын гүйцэтгэл 1,288.4 сая төгрөг төлөвлөснөөс 24.6 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгө оруулалт: 2021 онд өөрийн хөрөнгөөр 25.0 сая төгрөгийн асфальт заводын цахилгаан хангамжийн ажлыг өмч хамгаалах зөвлөлийн хяналт дор “Эсгэл” ХХК –тай гэрээ байгуулан бүрэн шийдвэрлэсэн.

ТӨБЗГ-ын 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 228 тоот шийдвэрийн дагуу тайлант онд 19.1 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай АЗЗА ТӨХК нь тайлант онд нийт 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 163 мэдээллийг ил тод хугацаанд нь байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-г хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг тулган шалгахад байгууллагын гүйцэтгэх захирлын 2021 оны Б/38 тушаалаар тэргүүний ажилчдын шагналд 4.9 сая төгрөг, өргөмжлөл, туузны зардалд 0.1 сая төгрөг, нийт 5.0 сая төгрөгийн шагнал, урамшуулал бусад зардал зардал гаргасан байна. Мөн байгууллагын бичиг хэргийн зардлыг хэмнэж ажиллаагүй байна. Энэ нь ЗГ-ын Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоол 1.6. “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.
- Шийдвэрлэсэн нь:** МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 118.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 118.9 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	6.6	2	6.6	-	-	100.0
Нийт дүн	2	6.6	2	6.6	-	-	100.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Архангай АЗЗА ТӨХК-ийн дараагийн тайлангийн аудитаар анхаарч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

- Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гаргасан эсэх, дотоод хяналттай холбоотой асуудлууд
- Худалдан авах ажиллагааг зохих заавар журмын дагуу явуулж байгаа эсэх

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 142.2 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрсэнд, аудитын явцад 137.2 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 2 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, орлого төвлөрүүлэлттэй холбоотой, өр төлбөрийн данстай холбоотой асуудлуудад 2 зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа

Аудитаар 137.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан Үүнд:

Тус байгууллагын Ерөнхий нягтлан бодогчийн гарын үсэг, анхан шатны баримтын бүрдэл дутуу 16.9 сая төгрөгийн баримтыг нөхөн гарын үсэг зуруулж анхан шатны иж бүрдлийг хангаж залруулав.

Тайланд онд замын арчлалтад зориулж авсан 50 тн давсны тээврийн хөлсийг гүйцэтгэгч компанитай гэрээ хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байсныг аудитын явцад нөхөн гэрээ хийлгүүлж, анхан шатны баримтын бүрдлийг хангав.

Монгол Хуондай Пробокс 15.5 сая, Бэлт трейд 9.2 сая, Автозам ХК 70.6 сая төгрөгийн ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээгүй байгааг аудитын явцад нөхөн гэрээ хийлгүүлэн залруулав.

АААЗЗАТӨХК/20212001 дугаартай худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичигт 15 тн БНД90/130, БНД100/130 маркийн битум худалдан авахаар Хостамирын уянга ХХК-тай гэрээ байгуулах эрх олгосон байна. Харин гэрээг байгуулахдаа 12 тн битум худалдан авахаар байгуулж санхүүжилтийг бүрэн олгосныг гүйцэтгэгч компаниас зөрүү дүнг нэхэмжлэн төлбөрийг хүлээн авч залруулга хийсэн.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөр, авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд дансны авлага 60.4 сая төгрөг болж өмнөх оны үзүүлэлтээс 46.5 сая төгрөгөөр, зорилтот түвшний төлөвлөгөөнөөс 48.9 сая төгрөгөөр өссөн, 2009 оноос хойш үлдэгдэлтэй байгаа 198.6 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өр төлбөрийг барагдуулаагүй.

Өгсөн зөвлөмж: Чанаргүй активийг бууруулж ажиллах стратеги хэрэгжүүлэх, олон жилийн насжилттай, өндөр дүнтэй өр төлбөрийг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах, холбогдох дээд шатны байгууллагуудад хүсэлт гаргах.

2. Орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 1,314.8 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсан, гүйцэтгэлээр 1,285.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 29.4 сая төгрөг буюу 2.2 хувиар орлогыг төлөвлөгөөг тасалдуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Захирал дараах эрх, үүрэгтэй”, 20.1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

[illegible]

Архангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			1,285.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 29.4 сая төгрөг буюу 2.2 хувиар орлогыг төлөвлөгөөг тасалдуулсан байна.												
6	Архангай АЗЗА ТӨХК	АРА-2022/222/НА-СТА-ТӨА	Тайлант онд дансны авлага 60.4 сая төгрөг болж 46.5 сая төгрөгөөр өссөн, 2009 оноос хойш үлдэгдэлтэй байгаа 198.6 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өр төлбөрийг барагдуулаагүй.		1	-								1	-
ДҮН				137.2	6	137.2	4	137.2						2	-
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
1	Архангай АЗЗА ТӨХК	АРА-2022/222/НА-СТА-ТӨА	Архангай АЗЗА ТӨХК нь тайлант онд нийт 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 163 мэдээллийг ил тод хугацаанд нь байршуулж, 10 хугацаа хоцроон байршуулсан байна.		1	-									
2	Архангай АЗЗА ТӨХК	АРА-2022/222/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх захирлын 2021 оны Б/38 тушаалаар тэргүүний ажилчдын шагналд 4.9 сая төгрөг, өргөмжлөл, туузны зардалд 0.1 сая төгрөг, нийт 5.0 сая төгрөгийн шагнал, урамшуулал бусад зардал зардал гаргасан байна. Мөн байгууллагын бичиг хэргийн зардал, дотоод албан томилолтын зардлыг хэмнэж ажиллаагүй байна.	5.0	1	5.0					1	5.0			
ДҮН				5.0	2	5.0					2	5.0			
НИЙТ ДҮН				142.2	8	142.2					2	5.0		2	-